



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Ажлын тусгай горимд шилжүүлэх тухай

Улсын онцгой комиссын 2021 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн “Коронавируст халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, ажлын хариуцлагыг өндөржүүлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” тухай 06 дугаар албан даалгаврыг үндэслэн коронавируст тархалт байгууллага хамт олон, гэр бүлийн хүрээнд нэмэгдсээр байгаа тул ажилтнуудын хөдөлгөөнд хяналт тавих, ажлын байранд халдвар тархах эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны нийт ажиллагсдыг 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн хавсралтанд заасан хуваарийн дагуу зайнаас болон цахимаар ажиллах ажлын тусгай горимд шилжүүлсүгэй.

2. Тусгай горимоор ажиллаж байгаа албан хаагчдад тухайн өдрийн цалин хөлсийг ажилласнаар тооцож олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын газрын нягтлан бодогч /Б.Одням/-д зөвшөөрсүгэй.

3. Ажлын зайлшгүй шаардлагаар дуудсан цагт ирж ажиллах, гар утсаар байнга холбоо барих боломжтой байхыг нийт ажиллагсдад үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр томилох тухай

“Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасны дагуу Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын өдрүүдэд 2022 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 06.00 цагаас эхлэн 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 06.00 цаг хүртэлх 9 хоногийн хугацаанд хариуцлагатай жижүүр томилох зорилгоор ТУШААХ нь:

1. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын өдрүүдэд Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас ажиллах хариуцлагатай жижүүрийн ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баярын өдрүүдэд үндсэн үүрэгт ажил болон нислэг техникийн осол, зөрчлийн талаар дүрмийн дагуу мэдээ, мэдээллээр хангахыг хариуцлагатай жижүүрт үүрэг болгосугай.

3. Баярын өдрүүдэд ажилласан хариуцлагатай жижүүрт хяналт тавьж ажиллах, энэ хугацаанд гарсан мэдээ, мэдээллийг нэгтгэж танилцуулахыг Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжээч Х.Наранхүүд даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/06

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын санал, зөвлөмж, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийн 3.3.24, 4.4.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэх журам”-ын шинэчилсэн өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.
2. Журмыг холбогдох байгууллагуудад хүргүүлж танилцуулах, албаны цахим хуудсанд байрлуулж, мэдээлэлж ажиллахыг бүртгэл, судалгааны мэргэжилтэн /С.Баттулга/-д даалгасугай.
3. Журмын дагуу аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах шинжээч /Х.Наранхүү/-д даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Шинжлэн шалгах багийг томилох тухай

Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Иргэний нисэхийн багц дүрэм 203-ын 8.1 дэх заалт, НТОЗШША-ны дүрмийн 2.2-ын заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр МИАТ ХК-ийн В767-300, JU-1021 бүртгэлийн дугаартай агаарын хөлгийн цахилгаан тэжээлийн эх үүсвэрүүд ажиллагаагүй болсон зөрчлийг шинжлэн шалгах багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Шинжлэн шалгах багийн ахлагч:

Х. Наранхүү, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжээч


Гишүүд: И. Энхчулуун, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны техникийн шинжээч

Я. Энхбаяр, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны нислэгийн хөдөлгөөний шинжээч

П. Гэрэлчимэг, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны бичлэг тайлагч

2. Шинжлэн шалгах ажиллагааг дүрэм, зааврын дагуу хийж гүйцэтгэхийг багийн ахлагч (Х.Наранхүү)-д үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Шинжлэн шалгах багийг томилох тухай

Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Иргэний нисэхийн багц дүрэм 203-ын 8.1 дэх заалт, НТОЗШША-ны дүрмийн 2.2-ын заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Төв аймгийн Аргалант сумын районд Монголиан Эйрвэйз ХХК-ийн Н125 (AS 350 В3) маягийн, JU-6888 бүртгэлийн дугаартай нисдэг тэрэг хээрийн буулт үйлдэж осолдсон шалтгааныг тогтоох шинжлэн шалгах багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Шинжлэн шалгах багийн ахлагч:

Х. Наранхүү, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжээч

Гишүүд: И. Энхчулуун, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны техникийн шинжээч

Я. Энхбаяр, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны нислэгийн хөдөлгөөний шинжээч

П. Гэрэлчимэг, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны бичлэг тайлагч

Ч.Сарансүх, МИАТ ХК-ний техникийн чанар баталгаажуулалтын менежер /тохиролцоогоор/

2. Шинжлэн шалгах ажиллагааг дүрэм, зааврын дагуу хийж гүйцэтгэхийг багийн ахлагч (Х.Наранхүү)-д үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН